

V ДЭЛХИЙН ФИЛОСОФИЙН СОНГОДОГ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БҮТЭЭЛЭЭС

Орчуулсан Хулуд Ж.Отгонбаяр

МУБИС

Толилуулах нь. Францын экзистенциалист Альбер Камю "Сизифийн тухай домог" зохиолдоо өөрийн философийн гол категори болох абсурд ба амиа хорлохуйн утгыг дүр дүрслэмж оролцуулан тайлбарласан байдаг. Камюг ойлгоно гэдэг чухамдаа абсурд билээ. Түүний Сизифийн тухай домог хэмээх зохиолоос дараахь хоёр өгүүллийг орчуулахдаа абсурд хэмээх категорийн философи утгыг хадгалахын учир монгол хэлнээ шууд авч хэрэглэснээ уншигч авхай нарт өчьсү.

СИЗИФИЙН ТУХАЙ ДОМОГ

А.Камю

Абсурдын тухай эссенүүд

Пиа Паскальд зориулав (1)

Абсурд эргэцүүлэл

Мөнхийн амьдралд бүү тэмүүл, сэтгэл чи

Мөнхийн боломжтой бүхнийг хүртэхийг хичээ (2)

Пиндар. Пифийн дуунууд(111.62-63)

Энэ удаагийн бичвэртээ манай зуунд хаа сайгүй гаарч буй абсурдын мэдрэмжийн тухай ярих болно. Үнэнийг хэлэхэд, манай үеийнхэнд төдийлөн танил болж дэлгэрээгүй абсурдын философийн тухай биш, харин мэдрэмжийн тухай л ярих юм. Эгэл шударга зан минь энэхүү бичвэрт орчин үеийн зарим сэтгэгчид чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг бүр эхнээсээ л хүлээн зөвшөөрөхийг надад тулгаж байна. Бүхий л бичлэгийнхээ туршид би эдгээрээс иш татах, бас тэдгээрийг тайлбарлах болно гэдгээ нуух нь утгагүй биз ээ.

Өнөөг хүртэл дүгнэлт мэтээр авч үзэж байсан абсурд миний хувьд эхлэх цэг байх болно гэдгийг бас тэмдэглэх нь зүйтэй юм. Энэ утгаараа миний эргэцүүллүүд урьдач таамаг шинжтэй болох бөгөөд учир нь ямар байр сууринд намайг хүргэхийг хэлэх аргагүй юм. Одоохондоо метафизик ч тэр, сүсэг бишрэл ч тэр холилдож хутгалдаагүй байгаа оюун санааны өвчнийг гагцхүү дангаар нь тодорхойлж байгааг та олж харах болно. Номын маань хамрах хүрээ ийм юм, түүний өгүүлэх цор ганц этгээд таамаг санаа нь тийм юм аа.

Абсурд ба амиа хорлохуй

Үнэхээр жинхэнэ философийн нэг чухал асуудал байдаг нь өөрийгөө өгүүтгэх тухай асуудал юм. Цаашид амьдрах уу, болих уу гэдгийг шийднэ гэдэг бол философийн суурь асуултанд хариулж байна гэсэн үг. Харин ертөнц гурван хэмжүүртэй эсэх, оюун санааны категориуд нь ес байна уу, эсвэл арван хоёр байна уу гэх мэт бусад бүх зүйл бол хоёрдугаар зэргийн асуудал юм. Тоглоомын нөхцөлүүд ердөө л энэ. Бүхнээс түрүүлж энд хариулт өгөх хэрэгтэй. Ницшегийн хүссэнчлэн, хүндэтгэл хүлээсэн философич үлгэр жишээг үзүүлж байх ёстой нь үнэн юм бол хариултын ач холбогдол ч ойлгомжтой, түүнийг тодорхой үйлдлүүд дагалддаг. Энэхүү илэрхий байдлыг зүрх сэтгэл ч зөнгөөрөө мэдэж байдаг боловч түүнийг улам тод болгохын тулд гүнд нь орж нягталж үзэх зайлшгүй шаардлагатай.

Нэг асуудал нөгөөгөөсөө илүү чухал, хойшлуулшгүй гэдгийг нь хэрхэн тодорхойлох вэ? Шийдвэрийг дагалдаж буй үйлдлүүдээр нь авч хэлэлцэх ёстой. Хэн нэг хүн онтологи аргументийн төлөө үхсэнийг би ерөөсөө мэдэхгүй. Галилей (3) шинжлэх ухааны зүй ёсны үнэнийг нээсэн ч амьдралд нь аюултай болоод ирэхийн цагт өнөөх үнэнээсээ ер бусын хялбархнаар няцаж буцсан юм. Ямар нэг утгаар түүний зөв байв (тийм зөвтгөл түүдэг галын ч үнэгүй айсан юм). Дэлхий Нарыг тойрно уу, Нар Дэлхийг тойрно уу, ялгаагүй юм гэж үү? Нэг үгээр хэлэхэд энэ бол хоосон асуулт. Гэлээ ч амьдарч өнгөрөөнө гэхэд амьдрал дэндүү утгагүй боллоо гээд олон хүн үхэж байгааг би бас харж байна. Амьдралынх нь үндэслэл болж буй үзэл санаа ба хуурамч бодлынхоо төлөө өөрийгөө өгүүтгэхэд бэлэн байгаа хүмүүсийг би мэдэж байна. Энэ бол ердөө ч хачирхалтай зүйл биш. Амьдрах шалтгаан гэгдэж буй тэр зүйл нь бас нэгэн зэрэг үхлийн гол шалтгаан болж байдаг.

Ийм учраас амьдралын утга учрын тухай асуудал бол бүх асуудлуудаас хамгийн хойшлуулшгүй нь юм гэж би үзэж байна. Хэрхэн түүнд хариулах вэ? Бүх гол асуудлуудыг эргэцүүлэх ердөө л хоёр арга байгаа нь илт бөгөөд эдгээрт би амьдралд заналхийлж байгаа, эсвэл амьдрах хүсэл тэмүүллийг арав дахин нэмэгдүүлж буй тэр зүйлийг хамруулан үзэж байна. Энэ бол Ла Палисс(4) ба Дон Кихотын аргууд юм. Илэрхий байх чанар ба хөөрөл бахдал хоёр бие биеэ тэнцүүлж буй зөвхөн тэр тохиолдолд л бид догдлолд ч, илт яруу тод утга санаанд хүрэх боломжийг олж авах юм. Тийм даруухан болоод тийм хөөрөл бахдал болсон зүйлийг судлан үзэх явцад эрүүл ухаан ба хүсэл сэтгэлд тулгуурласан оюуны чамлагдмааргүй чиг хандлагад сонгодог диалектикийн эрдэм оюун байраа тавьж өгөх ёстой.

Амиа хорлох явдлыг цаг ямагт үлэмж нийгмийн шинжтэй феномен гэж үзэж байлаа. Харин бид, эсрэгээр нь, анхнаасаа энэ асуудлыг хувь хүний сэтгэхүйтэй холбоотой гэж үзэж байна. Амиа хорлолт бол зүрхний гүнд алхимичдын (5) Их Үйлс шиг бэлтгэгдэж байдаг. Хүн өөрөө энэ тухай юу ч мэддэггүй, гэтэл нэг л сайхан өдөр өөрийгөө буудчихсан, эсвэл живээд үхчихсэн байдаг. Нэгэн амиа хорлогчийн тухай хүмүүс надад ярьсан юм. Тэрээр таван жилийн өмнө охиноо алдсанаас болж ихэд өөрчлөгдсөн бөгөөд энэ явдал түүнийг ийнхүү "өм идэж" дээлтэй нь хатаажээ. Илүү оновчтой үг олоход ч хэцүү байна. Ухаан сэтгэхүй ажиллах цаг болсон хэдий ч тэрээр хэдийнээ тамирдаж байна. Энд нийгмийн үүрэг эхлээд тийм их биш л дээ. Санааны зовлон, өт хорхой нь сэтгэл зүрхэнд байгаа, иймээс түүнийг тэнд л эрэх хэрэгтэй. Өөрийнхөө оршихуйн харилцааг дэндүү ухаарснаас үүдэн энэ ертөнцөөс зугтахад хүргэж буй тэрхүү тоглоомыг таньж мэдэх зайлшгүй шаардлагатай юм.

Амиа хорлох шалтгаан олон янз, тэгэхдээ тэдгээрээс хамгийн илэрхий нь хамгийн идэвхигүй, хүчгүй нь юм. Амиа хорлох явдал эргэцүүлэл, бясалгалын (рефлексийн) үр дүн байх нь ховор (тийм таамаг байж болохыг бас үгүйсгэдэггүй л дээ). Шийдэл тайлал нь бараг л байнгын хяналт, ухамсаргүй зүйл болдог. Сонин хэвлэлийн мэдээлж байгаа нь "янаг амраг, дотно сэтгэлийн гаслан", эсвэл "эмчлэгдэшгүй өвчнөөс" болсон гэсэн байдаг. Тийм тайлбарууд байж болох бүрэн үндэслэлтэй. Гэхдээ тэр өдөр нь цөхрөнгөө барагчийн найз хайхрамжгүй хандсан байж болох уу гэдгийг тайлбарлах хэрэгтэй бөгөөд хэрвээ тийм бол чухам тэр л буруутан гэмтэн

нь болно. Учир нь энэ яль шалигүй байдал өөрийгөө егүүтгэгчийн зүрхэнд хурсан уйтгар гаслан гадагш гэнэт дэлбэрч цоргиход хүрэлцээтэй шалтаг болж болох юм (Боломжийг ашиглан энэхүү эссенд яригдаж буй эргэцүүлэл бодомжуудын харьцангуй чанарыг тэмдэглэх байна: амиа хорлох нь илүү хүндэтгэх шалтгаантай холбоотой байж болох юм. Үүний жишээ гэвэл, Хятадын хувьсгалын үеэр "эсэргүүцлээс" болж гарсан амиа хорлолтууд нь улс төрийн шалтгаантай аж). Үхлийг сонгож буй тэр үл ойлгогдох, хоромхон зуурын эгшинг тодорхойлон тайлахад хэцүү байдаг бол үйлдлээс өөрөөс нь дүгнэлт хийхэд хамаагүй хялбар юм. Тодорхой утгаар авч үзвэл, амиа хорлох явдал нь яг л мелодрамын үзэгдэл шиг үнэнд гүйцэгдэж, бууж өгөхтэй адил юм. Өөрийгөө егүүтгэнэ гэдэг бол амьдрал ойлгомжгүй болсныг, бас дуусгавар болж байгааг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг. Холоос адилтгал татахаа больж, ердийн хэл рүүгээ эргэж оръё. Ерөөсөө л "амьдрахаа больё" гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Амьдарна гэдэг нь ямагт хэцүү байдаг билээ. Бид шаардлагатай үйлдлүүдээ хамгийн олон янзын, тэгэхдээ юуны өмнө заншил зуршлын шалтаг шалтгаанаар үргэлжлүүлэн хийж байдаг. Сайн дурын үхэл нь эдгээр заншил зуршлын юу ч биш өчүүхэн болохыг, зөнгөөрөө ч гэнэ үү, хамаагүй, хүлээн зөвшөөрөх, амьдралыг үргэлжлүүлэх ямар нэг шалтгаан байхгүйг ухамсарлах, өдөр тутмын хөл үймээний утга учиргүй байдал, зовлон зүдгүүрийнхээ үр ашиггүй гэдгийг ойлгох явдал юм.

Амьдралд зайлшгүй шаардлагатай хүсэл мөрөөдлөөс ухааныг хөндийрүүлж хөсөр хаяхад хүргэдэг энэ бүүр түүр мэдрэмж чухам юу вэ? Тайлбарт өртөгдөж буй ертөнц бол хамгийн мунхаг ч бай, ер нь бидэнд танил ертөнц юм. Гэвч Орчлон хэрэв хуурмаг санаанаас ч, танин мэдэхүйгээс ч гэнэт хагацах тохиолдолд хүн түүний дотор хэн ч биш, гадных болдог юм. Хүн бол үүрд хөөгдсөн амьтан юм, учир нь тэр алдагдаж гээгдсэн ертөнцийнхөө тухай ой дурдатгал болон хүслэн болсон бодит байдлынхаа итгэл найдвараас тасран холддог. Үнэнийг хэлэхэд, абсурд байдлын мэдрэмж бол хүн ба түүний амьдрал, жүжигчин ба тайз заслын хоорондын эвдрэл, үл авцалдах байдал юм. Амиа хорлох тухай хэзээ нэгтээ бодож үзсэн бүх хүмүүс дээрх мэдрэмж ба үл оршихуй руу зүтгэх хүч хоёрын хооронд шууд холбоо хамаарал байгааг тэр дороо хүлээн зөвшөөрдөг. Миний эссений судлагдхуун бол абсурд ба амиа хорлохын хоорондхи яг энэ холбоо, амиа хорлолт нь ямар хэмжээнд абсурдын төгсгөл болдог вэ гэдгийг

тайлбарлах явдал юм. Өөрийгөө булхайдаж, луйварддаггүй хүний тухайд түүний үнэн гэж итгэсэн тэр зүйл зарчмын хувьд үйлдлүүдийг нь зохицуулдаг. Тийм тохиолдолд оршихуйн абсурд байдалд итгэх итгэл сүсэг нь тухайн үйлдлийн удирдамж болох ёстой. Ийм дүгнэлтийг дагаад энэ бүүр түүр байдлаас аль болох түргэн гарах гарц гарч ирэхгүй гэж үү? Хуурамч бахдалгүй бөгөөд тодорхой тавигдсан эл асуулт зүй ёсных юм. Энэ нь өөрөө өөртэйгээ зөвшилцөлд амьдрах чадвартай хүмүүсийн тухайд яригдаж буй нь ойлгомжтой юм.

Ингэж товч тодорхой тавихад уг асуудал маань энгийн, шийдвэрлэгдэшгүй мэт санагдаж байна. Асуулт энгийн байх нь мөн адил энгийн хариулт шаарддаг, нэгэн илт тодорхой байдал хялбархаан гэгчээр нөгөөг араасаа татаж дагуулдаг гэж санавал алдаа болохсон билээ. Хэрвээ асуудалд нөгөө талаас нь, хүмүүс амиа хорлодог уу, үгүй юу гэдгээс үл хамааран хандвал ерөөсөө л “тийм”, “үгүй” гэсэн философийн хоёр янз шийдэл байж болох нь априори байдлаар тодорхой болох юм шиг санагдана. Гэхдээ энэ бол дэндүү хялбар юм. Нэгэн утгат шийдэлд хүрч ирээгүй бөгөөд байнга асуун шалгааж байдаг хүмүүс бас бий. Олонхийн тухай ярьж байна гэх егөөдсөн хачирхалтай тохиолдлоос би хол байна. Түүнчлэн “үгүй” гэж хариулсан олон хүн “тийм” гэж хариулсан юм шиг үйлдэл хйицгээдэг нь ойлгомжтой юм. Хэрвээ Ницшегийн шалгуурыг хүлээн авах юм бол тэд яасан ч байсан “тийм” гэж ярьцгаадаг. Харин амьдрал утга учиртай гэдэгт амиа хорлогчид ямагт итгэцгээж байдаг. Ийм маягийн зөрчлүүдтэй бид байнга тулгарч байдаг. Тэр байтугай логик (оюун санаа, бодох санах) хичнээн их үндэслэгдэнэ, тэр эгшинд зөрчил улам хурцаддаг гэж хэлж болно. Философийн онолуудыг шүтэн баримтлагчдынх нь авир үйлдэлтэй байнга харьцуулж байдаг. Харин амьдралаас татгалзсан сэтгэгчдийн дотор, өөрөөр хэлбэл, Перегрины (6) домгоос үүсч, Жюль Лекъегийн (7) таамгийг шалгасан, утга зохиолоор бий болсон Кирилловоос гадна, хэн ч амьдралаас өөрөөс нь татгалзахын тулд логиктойгоо тийм зөвшилцөлд байгаагүй юм. Хошин наргиа болгогч тэд тансаг зоогийн төлөө амиа хорлохыг магтан алдаршуулагч Шопенгауэрт байнга хандаж, тэндээс ишлэл авч байна. Гэхдээ тоглоом тоотой нь дээр. Эмгэнэлт байдлыг анхааралтай хүлээж авахгүй байна гэдэг нь тийм ч чухал биш, ийм маягийн хайхрамжгүй байдал нь эцсийн эцэст хүнд өөрт нь ялын тогтоол авчирдаг.

Тэгэхлээр, эдгээр зөрчлүүд, мөн энэ учир битүүлэг байдалтай тулгарснаараа амьдралын тухай боломжит санал ба түүнийг орхихын тулд хийгдэж буй үйлийн хооронд ямар ч холбоо хамаарал байхгүй гэж үзэх хэрэг байна уу? Хэтрүүлж үнэлэхээ больцгооё. Хүн ертөнцөд татагдаж хоргодоход ертөнцийн бүх зовлонг бодвол илүү хүчтэй нэгэн зүйл бий. Шийдвэр гаргахад ухаанаас (эн тэнцүү) яагаад ч багагүй байдлаар бие оролцож байдаг. Тэгээд ч бие үл оршихуйн өмнө няцаж, зүрх алдаж байдаг. Бид сэтгэх үйлдэлд дадаж хэвшихээсээ түрүүлээд амьдрах хэвшил дадалтай болсон байдаг. Энэхүү урьдач байдлыг бидний үхлийн цагийг алхам алхмаар ойртуулсаар буй өдөр хоногийн урсгалд бие хадгалж авч явдаг. Эцэст нь хэлэхэд, зөрчлийн утга учир нь би "зайлсхийлт" гэж нэрлээд буй Паскалийн (8) "зугаацлаас" нэгэн зэрэг их бөгөөд бага тэрхүү зүйлд байгаа юм. Үхлээс зайлсхийлт бол миний эссений гуравдугаар сэдэв бөгөөд энэ бол итгэл найдвар юм. Энэ бол "олж хүртэх" шаардлагатай өөр амьдралд итгэх итгэл найдвар буюу өөрийн амьдралын төлөө биш, харин амьдралд уриалан дуудагч, амьдралыг гэрэлтүүлэн гийгүүлэгч, амьдралд утга учир олгогч ямар нэг агуу үзэл санааны төлөө амьдрагч хүмүүсийн арга мэх юм.

Энэ бүхэн бидний картуудыг будлиулж байна. Амьдралыг утгагүй дэмий зүйл болгон авч үздэг үзэл бодол амьдрах хэрэггүй гэсэн санаатай адил мэтээр аажмаар зөвшөөрөгдсөн ажээ. Үнэн хэрэгтээ эдгээр санаа бодомжуудын хооронд ямар ч зайлшгүй холбоо хамаарал алга байна. . Ерөөсөө л сандрал бачимдал, хэрүүл маргаан, туушгүй байдалд автах ёсгүй бөгөөд бодитой асуудлуудыг шууд барьж авах хэрэгтэй. Амьдрах итгэл горьдлогогүй, нэг ёсондоо амьдрах хэрэггүй болоод л амиа хорлоцгоож байгаа нь, мэдээж хэрэг, үнэн юм, гэхдээ энэ бол хэн бүхний мэддэг (трюизм), үр ашиггүй, улиг болсон үнэн юм. Гэхдээ оршихуйн энэ хараал идсэн, халж цөхсөн байдал, худал хуурмаг дахь амьдралыг илчилж байгаа нь амьдралд утга учир байхгүйн үр дагавар юм гэж үү? Амьдралын абсурд байдал нь итгэл найдвар луу, эсвэл амиа хорлолт руу тийш зугтахыг шаардаад байгаа юм уу? Бусад бүх асуудлыг орхиод чухам үүнийг л бид мөрдөн мөшгиж, тайлж тайлбарлаж, таньж ойлгох ёстой юм. Абсурд нь үхэл рүү хөтөлдөг гэж үү? Энэ бол сэтгэлгээний аргууд байна уу, эсвэл оюун санааны тэвчингүй тоглоом байна уу, ялгаагүй бүх асуудлын дотроос нэгдүгээрх нь юм. Нарийн ялгаа, зөрчлүүд, "объектив чанарын ухаан

санаагаар" чадварлаг нэмэлт болгосон бүхнийг тайлбарлагч психологи зэрэг эдгээр бүхэнд энэхүү эцэж цуцашгүй эрэл хайгуултай адил төсөөтэй нийтлэг зүйл огт үгүй билээ. Түүнд зөв биш, тухайлбал, логик сэтгэлгээ хэрэгцээтэй байна. Энэ тийм хялбар олдохгүй. Ер нь сэтгэлгээ ямагт логик шинжтэй зүйл байдаг ч, харин эцсээ хүртэл логик шинжтэй байх бололцоо бараг үгүй юм. Энэ логик шинж нь мэдрэмжиндээ захирагдан замнаснаар эцэстээ хүрч буй амиа хорлогчид шиг л юм. Амиа хорлохуйн тухай эргэцүүлэх явдал миний сонирхлыг татагч нэгэн асуудлыг тавих боломжийг надад олгож байгаа юм, үхэх хүртэл үргэлжлэн үйлчилж байдаг тийм логик гэж байдаг уу? Гагцхүү хүсэл шуналын эмх цэгцгүй байдлаас ангид бөгөөд илт тодорхой байдлын гэрэл гэгээний үр дүнд бий болсон тунгаан бодохуйн тусламжтайгаар би үүнийг мэдэж чадна. Абсурд шинжтэй гэж миний нэрлээд байгаа тунгаан бодохуйн эхлэл ингэж гарч ирж байна. Олон хүмүүс ингэж эхэлцгээсэн, тэд эцэстээ хүрч очсон эсэхийг харин одоохондоо би мэдэхгүй байна.

Ертөнцийн нэгдмэл байдлыг оюун санаа, сэтгэлгээгээр байгуулах бололцоогүй гэдгийг харуулсан Карл Ясперс ийнхүү уулга алдсан байдаг, "Энэ хязгаар намайг өөр рүү минь, миний төсөөллүүдийг нийлбэр цогц байдалд хүргэж байгаа объектив үзэл бодлын ард би хэдийнээ нуугдахаа болсон тэр газар луу, би өөрөө ч, нөгөө хүний экзистенци ч миний хувьд объект болж чадахгүй тэр байдал руу хөтөлж байна". Тэрээр бусад олон хүний араас даган сэтгэхүй өөр хил хязгаарт ойртож буй тэрхүү (усгүй цөл) атар зэлүүд байдлын тухай сануулж байна. Тэр бусдын нэгэн адилаар ярьж буй нь ойлгомжтой ч эдгээр хязгаарыг орхих гэж тун ч давшингуй тэмүүлж байна! Сэтгэхүйн үндэслэлийг ганхуулсан энэхүү сүүлчийн эргэлт тийш олон хүн, тэдний дотор үл таних хүмүүс ч ирцгээсэн. Тэд үнэ цэнэтэй, амьдрал нь болж байсан бүхнээс няцаж буцсан. Бусад нь, оюун санааг өргөмжлөгчид, бас л няцацгаасан, гэхдээ сэтгэлгээний эсрэг шууд ил үймээн дэгдээж, сэтгэхүйн амиа хорлол руу явж байна. Үүний шууд эсрэг шинж хандлага нь хүч дэмжлэг үгүйлж байна, аль болох дээд хэмжээнд нь сэтгэлгээний хурц тод байдлыг хадгалах, сэтгэхүйн зах хязгаарт үүссэн хачирхалтай хэлбэрүүдийг ойр дэргэдээс нь авч үзэхийг оролдох хэрэгтэй байна. Сөрөг дүр (үгс) нь итгэл найдвар, эсвэл үхэл болон хувирч солигддог энэхүү абсурд бөгөөд хүнлэг бус драмын онцгой эрхтэй үзэгчид нь тууштай шаргуу байдал, нэвтэрхий саруул ухаан хоёр юм. Оюун ухаан өөрөө сэргээж хөгжөөхөөс өмнө одоо энэхүү энгийн болоод хөгжингүй нарийн бүжгийн

дүрүүдийг задлан шинжлэх ажилд орж болох билээ.

Зүүлт, тайлбар

2. Пиа Паскаль бол Камюгийн найз, тэд эхлээд П.Пиагийн үүсгэн байгуулсан "Бүгд найрамдах Алжир" сонинд 1930-аад онуудад хамтдаа ажилласан, дараа нь 1944 онд "Комба сонины газарт Пиа захирал болж, тэнд Камюгийн өгүүллүүд тогтмол хэвлэгдэж байлаа.
3. Пиндар (М.Т.Ө. 518-442, эсвэл 438 оны орчим) бол эртний грекийн уянгын яруу найрагч. Камю, магадгүй, П.Валерийг унших явцдаа энэхүү хоёр мөртийг анхааралдаа авсан байж болох юм. Тэрээр "Морское кладбище" шүлгийнхээ эпитаф болгон үүнийг ашигласан байдаг.
4. 1633 онд Ром дахь эрүүдэн шүүх ажиллагааны үеэр Галилей өөрийнхөө "төөрөгдлөөс", өөрөөр хэлбэл, наран төвт сургаалаас буцаж, нүглээ наманчилсан тухай ярьж байна.
5. Ла Палисс (жинхэнэ нэр нь Жак де Шабанн (1470-1525) бол "Итал руу хийсэн аялалуудад оролцож Павии орчмын тулалдаанд амь үрэгдсэн Францын маршал юм. Цэргүүд нь түүний эр зоригийг магтан зохиосон дуунд бадаг бүр нь "за четверть часа до смеоти он был еще жив" гэсэн үгээр эхэлдэг.Хожим зоригт жанжны нэр зүйр цэцэн үгэнд "тос, тослог" гэх маягийн хэвшмэл хэллэг, сул үгийг Францад"лапалиссад" гэж нэрлэх болжээ. Харин Камю "лапалиссад"-ад ямар ч холбогдолгүйгээр Ла Палиссын нэрийг дурдсан бөгөөд жирийн дайчны эр зоригийн тухай ярьж байна.
6. Их Үйлс гэдгийг дундад эртний алхимичид зөвхөн металлуудыг алт болгон хувиргадаг чадмань эрдэнэ буюу философийн чулууг хийх төдийгөөр биш, мөн бэлгэдлийн утгаар, сэтгэл материаллаг эхлэлийн байдлаас оюуны гэгээрэл рүү, Абсолютыг танин мэдэх рүү шилжиж буй шилжилт хэмээн ойлгоцгоож байв. Камюгийн абсурд ертөнцөд "Зүрхний аниргүйд" амиа хорлох тухай санаа төрдөг.

Сизифийн тухай домог

Бурхад Сизифт ял оноожээ. Тэрхүү ял нь гэвэл уулын шовх оройд түүний өнхрүүлж гаргасан үхэр хад нь буцан унаж, тэрээр түүнийг дахин дахин дээш өргөн мацаж байх эцэс төгсгөлгүй үйл байлаа. Ийм зовлонт үйлээс өөр аймшигтай хүнд шийтгэл гэж үгүй хэмээн тэд боджээ.

Хэрвээ Гомерт итгэх аваас, Сизиф¹ бол эгэл борчуудаас хамгийн цэцэн цэлмэг, сонор сэрэмжтэй нь байсан гэдэг. Гэхдээ бас өөр эх сурвалжид, тэрээр дээрэм хийж амьдардаг байсан гэнэ. Тийм байлаа ч гэсэн энэ нь бидний хувьд ялгаагүй, эсрэг тэсрэг утгатай биш л дээ. Тэрээр хэрхэн яаж үүрдийн тамын ажилчин-боол болсон тухайд янз бүрийн санаа бодлууд байдаг. Юуны өмнө бурхдыг ойшоож үзэлгүй, хуумгай зохисгүй харьцсан гэж түүнийг буруутгажээ. Сизиф бурхдын нууцыг задруулж дэлгэдэг байж. Жишээ нь, Асопын охин Эгинаг Юпитер бурхан хулгайлсан явдлыг тэр илчилжээ. Охиноо хулгайд алдаж дургүй нь хүрсэн эцэг нь Сизифт гомдол мэдүүлжээ. Хулгайн тухай тэр мэдэж байсан болохоор хэрвээ гол усны бурхан Асон Коринф цайзад нь ус өгвөл ачийг хариулж туслахаар амалжээ. Ийнхүү тэрээр дээд тэнгэрийн өршөөл зарлигаас газар дэлхийн усыг илүү адис ерөөлтэй хэмээн эрхэмлэн үзжээ. Үүнийхээ төлөө тэрээр тамын зовлон эдлэх болжээ. Сизиф бас Үхлийн бурханыг дөнгөлж, үхэх хэмээх үйлийг үгүй хийн ертөнцийн жамыг өөрчилсөн тухай Гомер мөн өгүүлдэг. Эрлэг тамын эзэн Плутоны хувьд тамд нь хэн ч ирэхгүй, үгүйрч хоосрохыг үзнэ гэдэг тэвчиж баршгүй доромжлол байлаа. Тэрээр дайны бурхан Аресыг тушаан илгээж Үхлийн бурханыг Сизифийн гараас мулталж суллуулж байжээ.

Бас нэг эх сурвалжаар бол, Сизиф өөрийнхөө үхэхийг урьдчилж мэдээд эхнэрийнхээ хайрыг сорьж сонжихоор шийдэж өөрийнхөө хүүрийг оршуулж нутаглуулалгүй олны нүдэнд ил задгай хаяхыг түүнд тушаал болгосон гэж ярьцгаадаг. Тэгээд Сизиф тамд унажээ. Хүнлэг ёсонд дэндүү харш харгис байдлаар тушаалыг нь үг дуугүй дагасан эхнэртээ жигшин зэвүүцэж, хорсож занасан Сизиф түүнийг яллахаар Плутон бурхнаас Замбативд буцаж ирэх зөвшөөрөл авчээ. Харин дэлхий ертөнцийг дахин харж, нар ус, хад чулуу, тэнгис далайн дулаан зөөлнийг мэдэрсэн түүнд тамын ерцөнтөд эргэж

очмооргүй санагджээ. Тэрээр бурхдын сануулга, анхааруулгыг үл тоосонд тэдний уур хилэн дүрэлзсээр байлаа. Тийнхүү Сизиф олон жилийн туршид тэнгис далай цалгилж, газар дэлхий баяссан булан тохойн эрэг ирмэгт аж төрлөө. Бурхад хүч албадлага хэрэглэхээс өөр аргагүй боллоо. Тэгээд дээд тэнгэрийн бошгоор Меркурий бурхан заларч Сизифийг цаламдан оосорлож, заамдан барьж, шийтгэлийнх нь үхэр хад хүлээж байгаа тамын орон руу үүрд авч оджээ.

Энэ бүхнээс харахул, Сизиф бол **абсурд** баатар гэдэг нь ойлгомжтой. Түүний хүсэл шунал, нажид зовлон нь тийнхүү гүнзгий зөрчлөөр дүүрэн байх ажгуу. Бурхныг үл тоосон, үхлийг үзэн ядаж, амьдрахыг хүссэн зэрэг нь түүнд төсөөлшгүй зовлон боллоо. Тэр тэгж хамаг хүчээ ямар ч зорилгогүй шавхах болжээ. Газар дэлхий дээр амьдрах гэж хоргодсон хүсэл шуналынх нь төлөөс тийм аж. Тамын орноо Сизиф хэрхэн тарчилж байсан тухай өөр дэлгэрэнгүй, нарийн ширийнийг бид мэдэхгүй. Учир нь домог бол гол төлөв бидний сонирхол төсөөллийг л татахуйцаар зохиогдсон байдаг. Бид гагцхүү үхэр хадыг хүчлэн өргөж, түлхэж, уул өөд мацаж буй махарч хөвчирсэн хүнийг л төсөөлж байна. Үрчилдэж таталдсан нүүр царай, чулуунд шахаж наалдсан хацар, хүнд ачааг байдгаараа хөшиж тулсан шавар шавхайтай мөр, бүдэрч сөхөрсөн хөл, бул хадыг дахин дахин өргөх хиртэж саарьтсан гар, цэврүүтсэн алга л бидний нүдэнд үзэгдэнэ. Урт удаан хугацааны шаргуу хүчин чармайлтын дүнд, тэнгэр газар нь хаяа нийлсэн орон зайд, эхлэл төгсгөлгүй цаг хугацаанд сая л нэг юм зорьсондоо хүрч уулын оройд гарч ирнэ. Тоолох төдий эгшинд үхэр хад нь уруугаа өнхөрч уулын бэлд хүрнэ. Сизиф зовлонт тэр ажлаа дахин эхнээс нь хийх хэрэгтэй болохыг дуугүй харж зогсоно. Тэгээд тэр доош, хад тийш алхаж эхэлнэ.]

Яг энэ эгшинд Сизиф миний сонирхлыг татаж байгаа юм. Түүний зүдэрч туйлдаж, хатингиршсан нүүр царай нь хаднаасаа дөнгөж л ялгарах төдий юм. Хязгааргүй зовлонт ажил руугаа хөлөө хүндээр зөөж тавих боловч **нэгэн жигд алхлан** бууж очихыг нь би харж байна. Яг энэ үед амьсгалах агаартай нь хамт хагацашгүй зовлон шиг нь аймшигтай ухаарал толгойд нь орж ирж байгаа юм. Ингээд агшин бүрт, уулын оройгоос бурхдын хөндий хүртэл бууж ирж байхдаа тэрээр өөрийн хувь тавилангаасаа улам улам дээшилнэ. Тэрээр хаднаасаа ч хатуужина.

Зохиолын баатар нь зовлонт амьдралаа мэдрэх оюун ухаантай тул энэ домог эмгэнэлтэй юм. Хэрвээ алхам тутамд нь амжилтанд хүрнэ гэсэн итгэл найдвар түүнд байгаа юм бол ямар ял шийтгэлийн тухай ярьж болно вэ? Өнөөгийн ажилчин яг ингэж амьдарч байгаа ба түүний хувь заяа нь түүнээс ч багагүй эмгэнэлтэй. Гэхдээ түүнд ой ухаан нь эргэн ирж, тэр өөрөө энэ байдлаа ухамсарласан ховорхон тэр л агшинд эмгэнэлтэй гэдгээ мэдэрнэ. [Бурхдын боол, үгээгүй, зовлонт эр, хүчин мөхөс, үймээнч түйвээнч Сизиф гунигт хувь заяаныхаа эцэс төгсгөлгүй гэдгийг мэдэж байна.] Энэ тухайгаа тэрээр уулнаас доош буух үедээ л боддог. Хувь тавилангаа нэгэнт танин мэдэх болсон нь түүний зовлонгийн эх сурвалж биш, харин түүний ялалт болон эргэж урвана. Зэвүүцэл дургүйцэлд дийлдэхгүй хувь заяа гэж байдаггүйсэн.

Заримдаа түүнийг уулнаас бууж ирэх, түр амсхийлт нь тэр аяараа зовлон байсан ч баясгалан болж болох юм. Энэ бол үнэн үг шүү. Би дахиад л өнөөх хад чулуу уруугаа бууж ирж буй Сизифийг төсөөлж байна. Эхлээд тэр чигээрээ зовлон шаналал байлаа. Ой тойнд ертөнцийн зовлон дүүрч, аз жаргалын мөрөөдөл хүслэн бүтэшгүй болоход хүний зүрх сэтгэлийг уйтгар гуниг эзэмдэх болдог. Энэ бол хад чулууны ялалт, энэ бол хад чулуу өөрөө юм. Хэмжээлшгүй уй гашууг тээж явна гэдэг үлэмж хэцүү. Бид Гефсиманы цэцэрлэгт өнгөрүүлсэн шөнүүд яг тийм хүнд байсан. Гэвч биднийг эзэмдэн дарангуйлах аймшигт үнэнийг ухаарч таних тусам тэрээр тийм аймшигтай байхаа больдог. Эдип хаан яг л ийнхүү хувь заяагаа мэдэхгүй байсан ба эхэн үедээ түүнд захирагдмал байв. Ухаарч таньж мэдсэнээр л эмгэнэлт байдал эхэлж байна. Харин тэр үед л цөхөрч шаналсан, сохор Эдип өөрийгөө ертөнцтэй холбох цор ганц холбоос нь хайртай охиных нь зөөлөн гар болохыг ухаарна. Тэгэхэд л түүний ихэмсэг үг ийнхүү цууриатдаг: <<Аливаа гай түйтгэр тохиосон ч түүнийг үл харгалзан, өтөл өндөр нас болон сэтгэлийн сүр хүч хоёр маань намайг бүх юм сайн сайхан байна гэж хэлэхэд хүргэж байна>>². Достоевскийн зохиолд гардаг Кирилловтай адил Софоклийн жүжгийн Эдип хаан абсурд ялалтын томъёолол утгыг бидэнд өгч байна. Эрт цагийн мэргэн ухаан ба орчин үеийн баатарлаг үзэл хоёр нэг дор сүлэлдэж байна.

Абсурдыг нээж олсон хэнд ч аз жаргалын сурах бичиг гэмээр нэг юм бичмээр хүсэл бодол ямагт төрдөг юм. <<Ийм зовлонт нарийн замаар явж

байж яаж?...>>. Гэвч хорвоо ертөнц ганцхан болохоор аз жаргал ч абсурд ч хоёул нэг л эх сурвалжийн бүтээлүүд юм. Энэ хоёр салж хагацашгүй холбоотой. Гагцхүү абсурдыг нээснээр л аз жаргал ирдэг гэвэл алдаа болох юм. Абсурд мэдрэмж аз жаргалаас үүсэх тохиолдол ч байж болдог. <<Бүх зүйл сайн байна гэж бодож байна>> гэсэн Эдип хааны үгс ариун үнэн юм. Хатуу ширүүн, эцэс төгсгөлгүй хүний орчлонд л тийм үгс цууриатдаг юм. Энэ үгс бас болоогүй бүгд биш, бүх юм шавхагдан дуусчихаагүй байна гэдгийг тэд л харуулж сэнхрүүлдэг. Хангагдаагүй хэрэгцээ, зорилгогүй, зовлон зүдэргээтэй хамт энэ ертөнцөд бууж ирсэн бурхдыг ч тэд л хөөж явуулдаг. Тэд хувь заяаг хүний гарын үйл хэрэг болгодог. Энэ үйл хэрэг хүмүүсийн дунд шийдвэрлэгдэх ёстой.

Энд л Сизифийн бүхий л чимээгүй даруухан, амгалан жаргалан оршимой. Түүний хувь заяа түүнд өөрт нь байна. Үхэр хад ч түүний өмч нь юм. Абсурд хүн яг ингэж өөрийн зовлон шаналалаа харан байхдаа тэнгэр бурхдыг ч дуугүй болгож байна. Нам гүм орчлонд гэнэт мянга мянган содон дуу авиа шуугин асч дуулдана. Энэ бол ертөнцийн бүх дүр төрхийн ухамсаргүй бөгөөд нууцлаг, далд дуудлага юм. Ялалтын дотоод тал, мөн чанар болон үнэ цэнэ төлбөр тийм ажээ. Сүүдэргүйгээр нар үгүй, иймд шөнийг зайлшгүй танин мэдэх хэрэгтэй. Абсурд хүн <<Тиймээ>> гэж хэлнэ, түүний хүч оролдлого, тэмцэлд ямар ч төгсгөл хязгаар үгүй. Хэрвээ хувь хүний өөрийнх нь хувь заяа гэж байгаа бол тэр нь дээрээс урьдчилан тогтоож зураад өгсөн зүйл, тавилан огт биш. Ингэж тогтоогдсон тавилан нь сайндаа л хүн өөрөө түүний тухай хэрхэн бодож үзэж буйтай ойртож нийлнэ: тэрээр мөн дургүйцлийг төрүүлэх нь зайлшгүй. Бусад тохиолдолд тэр өөрийгөө амьдралынхаа эзэн гэж ухаарна. Хүн өнгөрүүлсэн амьдрал руугаа эргэж харж ханддаг үл мэдэгдэх тэр хоромхон агшинд Сизиф хад руугаа буцаж ирээд хувь заяа болсон уялдаа холбоогүй үйл явдлуудын дарааллыг эргэцүүлэн бясалгадаг. Энэ хувь заяаг тэр өөрөө бүтээсэн, түүний ой тойноор дамжин нэг цул бүхэлд нэгдсэн бөгөөд үхэлтэй холбогддог ажээ. Хүмүүнтэй холбоо бүхий зүйл хүнээс үүсэлтэй гэдэгт итгэж харахыг хүсэгч, шөнө эцэсгүй үргэжлэхийг мэдэгч сохор хүмүүн зам мөрөө л хөөсөөр байх болно. Тэгээд хад дахиад л уруугаа өнхөрнө. Би Сизифийг уулын хормойд нь орхилоо! Зовлон дандаа л байдаг. Гэвч бурхдыг үгүйсгэж, хадыг хөдөлгөдөг дээд үнэнч чанарт Сизиф биднийг сургаж байна. Тэр бас л бүх юм сайн байна гэж үзэж байна. Энэхүү хорвоо эзэн тэнгэрээсээ хагацсан ч үүнээс

хойш Сизифт ямар ч хүртээлгүй зүйл мэт санагдахаа болино. Чулууны хэлтэрхий бүр, шөнө дундын уулан дээр гялтганах хүдрийн оч бүр түүний хувьд бүхэл ертөнцийг бүрдүүлнэ. Хүний сэтгэл зүрхийг эзэмдэж дүүргэхэд оройд хүрэх нэг л удаагийн тэмцэл хангалттай. Сизиф бол жаргалтай хүн юм гэж өөртөө төсөөлөх учиртай болж байна.

Тайлбар

1. Сизиф бол Эртний Грекийн шид домогт Эол ба Энаретейн эоланчуудын хааны хүү. Камю Сизифийн тухай хэд хэдэн домгийг сэргээн өгүүлж буй ч, Сизифийг залт шунахай этгээд гэж үздэг уламжлалыг орхиж байна. Амин хувиа хичээгч уг дээрэмчин зам явуулын хүмүүсийг том хадаар дарж алсны учир Аидэд шийтгэгджээ. Камю өөр бас нэг уламжлалыг орхисон байна. Тэр нь бидэнд хүрч ирээгүй Критигийн эмгэнэлт жүжиг байх бөгөөд түүнд Сизифийг бурхны дураараа аашлах байдалтай уран ухаанаар тэмцэгч баатар гэж дүрсэлжээ.

2. Эдип бол Эртний Грекийн домог сэтгэлгээнд мэдэхгүйн хар гайгаар эцгийгээ алж төрүүлсэн эхтэйгээ ханилсан Фиваны хаан. Хийсэн нүглээ мэдмэгц нүдээ сохлоод охин Аитгоныг дагуулан Грек даяар хэсүүчилнэ. Камю <<Бүгд сайн>> гэх <<хэтийдсэн үг яриа>>-г Эдип хэлсэн тухай бичиж байна. Харин Софоклын <<Эдип Колонд>> жүжгийн Эдипийн дүрийн тайлбар маргаан багатай юм.